



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх, балансаас
балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хэрэгжүүлсэн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжих” төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Стандарт, хэмжил зүйн газрын балансад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Саранжав, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн
20. дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**"Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газарт хэрэгжүүлсэн,
Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн
"Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжих" төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан,
Стандарт, хэмжил зүйн газрын балансад бүртгэх хөрөнгө**

Д/д	Автомашины төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Дахин үнэлгээ хийсэн үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Ландкрузер прадо-120", суудлын, 57-27 УБЧ	2009	106444	15,000,000.00	-	15,000,000.00
НИЙТ ДҮН:				15,000,000.00 (арван таван сая)		15,000,000.00 (арван таван сая)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн
20.. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансаас
"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашины төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Ниссан теана", суудлын, 84-95 УБТ	2006	106200	37,173,580.00	37,173,580.00	0
НИЙТ ДҮН:				37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян)	37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян)	